



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn  
Аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn  
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал: Т.Батсайхан  
Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com  
Аудитын менежер: Г.Оюунгэрэл  
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com  
Ахлах аудитор: Д.Алтайбаяр  
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаарлага.....	15
4.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУБШУ	Монгол Улсын боловсрол шинжлэх ухаан
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТТ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/181  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНЫ  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ц.ГИВААЖИД ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,752,321.00</b>	<b>67,377,473.70</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>500.00</b>	<b>00.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>500.00</b>	<b>00.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>500.00</b>	<b>00.00</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	500.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,874,041.00</b>	<b>00.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,874,041.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>69,877,780.00</b>	<b>67,377,473.70</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,651,575.00</b>	<b>1,746,255.00</b>
35130	Эм боох материал	1,651,575.00	1,746,255.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>67,836,205.00</b>	<b>65,241,218.70</b>
35410	Бичиг хэргийн материал	2,697,570.00	1,279,270.00
35420	Аж ахуйн материал	49,076,643.00	39,879,423.00
35440	Түлш, шатах тослох материал	5,564,000.00	8,248,107.70
35460	Хүнсний материал	1,102,674.00	4,895,890.00
35470	Бусад хангамжийн материал	9,395,318.00	10,938,528.00
35600	Мал амьтад	390,000.00	390,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,264,334,599.20</b>	<b>1,240,813,381.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,264,334,599.20</b>	<b>1,240,813,381.21</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,248,140,599.20</b>	<b>1,224,069,381.21</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,316,850,300.00	1,316,850,300.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-121,409,753.12	-149,597,179.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,936,886.00	30,088,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,721,094.44	-6,680,358.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,009,635.00	27,960,735.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,956,111.71	-14,509,785.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,872,600.00	36,994,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17,513,962.53	-19,109,130.21
39217	Ном	2,072,100.00	2,072,100.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>16,194,000.00</b>	<b>16,744,000.00</b>
39301	Програм хангамж	825,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,194,000.00	16,194,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,336,086,920.20</b>	<b>1,308,190,854.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>340,089.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>340,089.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>340,089.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	340,089.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,336,086,920.20</b>	<b>1,307,850,765.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,336,086,920.20</b>	<b>1,307,850,765.91</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	168,054,740.00	168,054,740.00
51101	Өмч: - төрийн	168,054,740.00	168,054,740.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,130,335,218.21</b>	<b>1,102,099,063.92</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,130,335,218.21	1,130,335,218.21
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-28,236,154.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,696,961.99	37,696,961.99
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,336,086,920.20</b>	<b>1,308,190,854.91</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>475,179,405.00</b>	<b>431,492,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,000,805.00</b>	<b>26,442,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>9,000,805.00</b>	<b>26,442,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,000,805.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,000,305.00	00.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	00.00	16,997,000.00
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	00.00	9,445,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,227,300.00</b>	<b>21,489,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	444,951,300.00	383,561,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>261,800.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	261,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>21,227,300.00</b>	<b>21,227,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,227,300.00	21,227,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>473,287,455.15</b>	<b>454,300,754.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>473,287,455.15</b>	<b>454,300,754.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>442,591,486.15</b>	<b>449,684,664.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>313,284,859.00</b>	<b>313,486,130.00</b>
210101	Үндсэн цалин	263,556,659.00	218,744,903.00
210102	Нэмэгдэл	23,588,300.00	71,277,985.00
210104	Урамшуулал	26,139,900.00	23,463,242.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,783,359.00</b>	<b>39,995,810.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,068,959.00	27,544,910.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,433,500.00	3,112,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,746,700.00	2,490,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	667,200.00	622,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,867,000.00	6,225,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,995,900.00</b>	<b>13,946,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,620,000.00	2,042,000.00
210302	Түлш, халаалт	8,412,500.00	9,100,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,963,400.00	2,803,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,858,110.00</b>	<b>17,954,352.30</b>
210401	Бичиг хэрэг	857,000.00	591,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,250,000.00	1,225,292.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	619,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,360,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,671,110.00	2,761,900.00
210408	Бараа материал акталсны зардал	970,000.00	12,757,060.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,050,231.00</b>	<b>13,632,154.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,980.00	29,120.00
210502	Хоол, хүнс	25,007,451.00	13,587,884.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,800.00	15,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>93,600.00</b>	<b>2,165,000.00</b>
210604	Урсгал засвар	93,600.00	2,165,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>70,000.00</b>	<b>70,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	70,000.00	70,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,091,900.00</b>	<b>796,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	741,900.00	395,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	400,000.00

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,363,527.15</b>	<b>47,639,117.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	286,000.00	929,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,324,100.00	6,191,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,753,427.15	40,518,217.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,695,969.00</b>	<b>4,616,090.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>540,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,319,369.00</b>	<b>2,471,590.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,319,369.00	2,471,590.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,836,600.00</b>	<b>2,144,500.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,836,600.00	2,144,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,891,949.85</b>	<b>-22,807,954.29</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>5,428,200.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	5,428,200.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-5,428,200.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,891,949.85</b>	<b>-28,236,154.29</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>151,860,740.00</b>	<b>1,192,707,433.95</b>	<b>1,413,620,632.95</b>
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>151,860,740.00</b>	<b>1,192,707,433.95</b>	<b>1,413,620,632.95</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	3,053,728.58	3,053,728.58
<b>C08</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>168,054,740.00</b>	<b>1,130,335,218.21</b>	<b>1,336,086,920.20</b>
<b>D01</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>168,054,740.00</b>	<b>1,130,335,218.21</b>	<b>1,336,086,920.20</b>
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>168,054,740.00</b>	<b>1,130,335,218.21</b>	<b>1,336,086,920.20</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-28,236,154.29	-28,236,154.29
<b>D09</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>168,054,740.00</b>	<b>1,102,099,063.92</b>	<b>1,307,850,765.91</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>466,179,100.00</b>	<b>405,050,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>500.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>500.00</b>	<b>00.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>500.00</b>	<b>00.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>466,178,600.00</b>	<b>405,050,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	444,951,300.00	383,561,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>261,800.00</b>

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	261,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>21,227,300.00</b>	<b>21,227,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,227,300.00	21,227,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>455,187,600.00</b>	<b>405,051,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>455,187,600.00</b>	<b>405,051,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>424,491,631.00</b>	<b>400,435,210.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>315,158,900.00</b>	<b>311,272,000.00</b>
210101	Үндсэн цалин	265,430,700.00	216,530,773.00
210102	Нэмэгдэл	23,588,300.00	71,277,985.00
210104	Урамшуулал	26,139,900.00	23,463,242.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,783,359.00</b>	<b>39,995,810.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,068,959.00	27,544,910.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,433,500.00	3,112,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,746,700.00	2,490,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	667,200.00	622,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,867,000.00	6,225,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,663,400.00</b>	<b>16,355,500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,620,000.00	2,042,000.00
210302	Түлш, халаалт	10,080,000.00	11,510,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,963,400.00	2,803,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,407,400.00</b>	<b>4,590,800.00</b>
210401	Бичиг хэрэг	581,500.00	300,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,250,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	750,000.00	619,000.00
210404	Ном, хэвлэл	251,700.00	109,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,360,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,214,200.00	2,062,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,261,672.00</b>	<b>18,743,800.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,075,500.00	123,800.00
210502	Хоол, хүнс	14,461,372.00	17,381,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,724,800.00	1,238,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,130,800.00</b>	<b>2,727,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,727,300.00	2,727,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>70,000.00</b>	<b>70,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	70,000.00	70,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,091,900.00</b>	<b>796,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	741,900.00	395,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,924,200.00</b>	<b>5,884,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	929,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,524,200.00	4,955,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,695,969.00</b>	<b>4,616,090.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>540,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>27,319,369.00</b>	<b>2,471,590.00</b>

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,319,369.00	2,471,590.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,836,600.00</b>	<b>2,144,500.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,836,600.00	2,144,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>10,991,500.00</b>	<b>-500.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>10,991,000.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10,991,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>10,991,000.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,991,000.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-10,991,000.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>500.00</b>	<b>(500.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>500.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	404,789,000.0	400,173,410.0	4,615,590.0	98.9
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	404,789,000.0	400,173,410.0	4,615,590.0	98.9
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	404,789,000.0	400,173,410.0	4,615,590.0	98.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	311,272,000.0	311,272,000.0	00.0	100.0
210101	Үндсэн цалин	216,203,200.0	216,530,773.0	-327,573.0	100.2
210102	Нэмэгдэл	71,607,500.0	71,277,985.0	329,515.0	99.5
210104	Урамшуулал	23,461,300.0	23,463,242.0	-1,942.0	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,021,700.0	39,995,810.0	2,025,890.0	95.2
210201	Тэтгэврийн даатгал	29,570,800.0	27,544,910.0	2,025,890.0	93.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,112,700.0	3,112,700.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,490,100.0	2,490,100.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	622,600.0	622,600.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,225,500.0	6,225,500.0	00.0	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,500,000.0	16,355,500.0	2,144,500.0	88.4
210301	Гэрэл, цахилгаан	3,640,000.0	2,042,000.0	1,598,000.0	56.1
210302	Түлш, халаалт	11,510,000.0	11,510,000.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,350,000.0	2,803,500.0	546,500.0	83.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,535,000.0	4,329,000.0	206,000.0	95.5
210401	Бичиг хэрэг	300,000.0	300,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.0	1,500,000.0	00.0	100.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	825,000.0	619,000.0	206,000.0	75.0
210404	Ном, хэвлэл	109,700.0	109,700.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,300.0	1,800,300.0	00.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,743,800.0</b>	<b>18,743,800.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,800.0	123,800.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	17,381,100.0	17,381,100.0	00.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,238,900.0	1,238,900.0	00.0	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,727,300.0</b>	<b>2,727,300.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	2,727,300.0	2,727,300.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>309,700.0</b>	<b>70,000.0</b>	<b>239,700.0</b>	<b>22.6</b>
210702	Дотоод албан томилолт	309,700.0	70,000.0	239,700.0	22.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>795,500.0</b>	<b>796,000.0</b>	<b>-500.0</b>	<b>100.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	395,500.0	395,500.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.0	500.0	-500.0	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,884,000.0</b>	<b>5,884,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	929,000.0	929,000.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,955,000.0	4,955,000.0	00.0	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>404,789,000.0</b>	<b>400,172,910.0</b>	<b>4,616,090.0</b>	<b>98.9</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>383,561,700.0</b>	<b>381,090,110.0</b>	<b>2,471,590.0</b>	<b>99.4</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	383,561,700.0	381,090,110.0	2,471,590.0	99.4
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>21,227,300.0</b>	<b>19,082,800.0</b>	<b>2,144,500.0</b>	<b>89.9</b>
132001	Орон нутгийн төсвөөс	21,227,300.0	19,082,800.0	2,144,500.0	89.9
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>500.00</b>	<b>-500.00</b>	<b>-</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>27.00</b>	<b>27.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	00.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>261,800.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>261,800.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>261,800.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	261,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	261,800.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	261,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>261,800.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261,800.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хатгал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж болон албан шаардлага өгсөн.

Аудитыг Ахлах аудитор Г.Оюунгэрэл, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Батсайхан хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэг нь “Цар тахлын үеийн түр мөрдөх дүрэм журмыг мөрдөж, цахим танхим хосолсон хүүхэд бүрийн эрүүл амьдрах, өөрийгөө хамгаалах зөв дадал, эерэг зан чанарыг хөгжүүлж, үндэснийхээ хэл, өв соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх” эрхэм зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн хөгжил сурах үйлийг дэмжиж агуулгын хоцрогдлыг нөхөн ажиллахад бүх талын оролцоо хамтын ажиллагааг хангаж, сургалт үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.

- Ажлын байранд эвсэг уур амьсгал бүхий байгууллагын соёл бүрдүүлж ,мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадварыг нэмэгдүүлэн цахим орчин зохистой хэрэглээг хэвшүүлэх
- Цэцэрлэгийн орчны аюулгүй байдлын стандарт шаардлагад нийцүүлэн , хоол үйлдвэрлэл , үйлчилгээний чанарыг сайжруулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх
- Багшийн ёс зүйг эрхэмлэн ажиллах
- Сургуульд бэлтгэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, залгамж холбоотой ажиллах
- Хүүхэд бүрийн хөгжилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх

- Хүүхэд бүрийн өөрийн онцлог, чадварыг судлах, ажиглалтын судалгааг чанартай хийж шинжлэх ухаанчаар ашиглах
- Сургалтын шилдэг арга зүй, технологийг эзэмшсэн бүтээлч баг хамт олны арга туршлага, хүүхдийн хөгжилд нөлөөлж буй амжилтыг үнэлж урамшуулж дэмжих
- СӨБ-н хамран сургах тойргийн судалгаа гаргаж, 5 настны хамран сургалтыг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 473.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27.9 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансны үзүүлэлтүүдтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	1.87	-	(1.87)
Бараа материал	69.88	67.38	(2.50)
Үндсэн хөрөнгө	1,264.33	1,240.81	(23.52)
Биет бус хөрөнгө	16.19	16.74	0.55
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,336.09</b>	<b>1,308.19</b>	(27.90)
Дансны өглөг	-	0.34	0.34
<b>Эздийн өмч</b>	<b>168.05</b>	<b>168.05</b>	-
-төрийн	168.05	168.05	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	37.70	37.70	-
Хуримтлагдсан үр дүн	1,130.34	1,102.10	(28.24)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,336.09</b>	<b>1,308.19</b>	(27.90)

Мөнгөн хөрөнгө данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Авлагын зөрүү 1.9 сая төгрөг байгаа нь ажилчидтай холбогдсон урьд оны авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.5 сая төгрөгөөр буурсан. Өөрчлөлтөд материаллаг нөлөөлөл бүхий зардлууд:

- Тайлант онд 42.0 сая төгрөгийн бараа материал худалдан зарцуулсан.
- Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны А/28 тоот тушаалаар 12.8 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 24.1 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд материаллаг нөлөөлөл бүхий зардлууд:

- Алаг-Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2021 оны 48 тоот тогтоолоор, 2021 оны 10 сарын 15-ны 62 тоот тогтоолоор нийт 2.9 сая төгрөгийн хөрөнгө акталсан.
- Алаг-Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2021 оны 62 тоот тогтоолоор 33.4 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлсэн байна.

Биет бус хөрөнгийн дансны үнэ 0.6 сая төгрөгөөр өссөн нь Алаг-Эрдэнэ сумын ИТХТ-ийн 2021 оны 62 тоот тогтоолоор программ хангамжийг дахин үнэлж авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 0.3 сая төгрөг нь ажилчидтай холбогдсон ХХОАТ-ын өглөг байна.

Хуримтлагдсан үр дүн 28.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 540.8 сая, орон нутгийн төсвөөс 29.1 сая нийт 569.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2021 оны анхны төсвийг тусгай зориулалтын шилжүүлгээс 430.4 сая төгрөг, орон нутгаас 21.2 сая төгрөг нийт 451.6 сая төгрөг баталсан бол тайлант хугацаанд төсөвт 1 удаа өөрчлөлт орж, төсвийг нийт 404.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Төсөвт зардлын санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээс 46.9 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Материаллаг зардлыг тодруулбал:

- Энэ онд цалин хөлс болон нэмэгдэл урамшил 22.7 сая төгрөг,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- Норматив зардал 72.6 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд ковидын хөл хорионы улмаас танхимын сургалт буурсантай холбоотойгоор төсвийн зардлыг бууруулж баталсан.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан нийт 404.8 сая төгрөг зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 383.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 21.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 400.2 сая төгрөг буюу 98.9 хувьтай байгаа ба ажил олгогчоос 2.0 сая төгрөг, байр ажиглалттай холбоотой тогтмол зардал 2.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 0.2 сая төгрөг, дотоод албан томилолтын зардал 0.2 сая төгрөгийн зардал тус тус хэмнэснийг буцаан төвлөрүүлсэн.

Хатгал сумын хүүхдийн цэцэрлэг нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөр: 71801 Сургуулийн өмнөх боловсрол

Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх

81835 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах

80109 – ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал

81807 – Цэцэрлэгийн хүүхдийн хоол

Хүснэгт 2. Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

Хөтөлбөр	арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71801	81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	210.9	208.7	2.2	99.0
71801	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	155.3	155.3	0.0	100
71801	80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	21.2	19.1	2.1	90.1
71801	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	17.4	17.4	0.0	100

Нийт хөтөлбөрийн биелэлтийг 92.3 хувиар үнэлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

МУБШУ-ны сайдын 2021 оны А/279 тоот тушаал, эрхлэгчийн 2021 оны А/47 тоот тушаалаар 0.2 сая төгрөг олгосныг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой санхүүгийн тайлангийн тодруулгын тайлбар танилцуулга ихээхэн дутуу байна. Үүнд шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны зорилго зорилттой холбоотой мэдээлэл, санхүүгийн тайланг бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, төсвийн гүйцэтгэлийн тайлбар танилцуулга, онцлох үйл явдлын тодруулга танилцуулга байхгүй байна.

- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас сургалтын хэвийн үйл ажиллагаа хязгаарлагдаж байсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 1.1 хувиар буюу 4.6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсвөөс 11.5 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэг төв нь 2021 онд нийт 558.8 сая төгрөгийн 49 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 558.8 сая төгрөгийн 49 мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав.

Зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайланд “Мөнгө нөөц баялаг” ХХК аудит хийж Төсвийн санхүүжилт үр ашиггүй зарцуулсан 1.9 сая төгрөг, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 4.5 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснээс зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

---

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд нийт 0,003 сая төгрөгийн бараа материалыг түлш халаалтын зардалд тайлагнасныг залруулав.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 0,003 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаарлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Хүүхдийн цэцэрлэг нь Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр сумын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын ХЗДХС-ын 2021 оны А/278 дугаар тушаалын 7 дугаар зүйлийн 7.1-т хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг тухайн хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг харьяалах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 1.1. Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх сум/тосгоны нэрийг тодорхой болгож Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт”-ийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан БАЙГУУЛЛАГЫН НЭР	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэг	1	0,003	1	0,003	0	0	0	0	1	0